

“ИЛТ ОНОЛЫН ЧИМЭГ” ДЭХ ХАМГИЙГ АЙЛДАГЧИЙН ГЕРМЕНЕВТИК ШИНЖИЛГЭЭ

Б.Түшихбаяр - Шашин судлалын тэнхмийн Докторант

Түлхүүр үгс: Buddhist psychology, Buddhist meditation, Prajna-Paramita, Abhisamayalamkara, Buddha, Sarvajna-jnana, Bodhisattva, Marga, Prayoga, Dhyana

Товч утга: Герменевтик аргазүйн нэг зорилго нь философийн болон шашны эх сурвалж дахь ойлголтуудын нийтээр хүлээн зөвшөөрөхүйц түгээмэл утгыг илрүүлэх явдал юм. Буддын билиг барамидын сургаалыг гол төлөв зава шастир гэж алдаршсан “Илт онолын чимэг” шастирт тулгуурлан номлох бөгөөд гагцхүү энэ шастирын утга агуулга нь шууд биш, гагцхүү тайлбарын тусламжаар тодорхой болдог. Эртний Энэтхэг, Төвд, Монгол мэргэдийн бичсэн олон арван тайлбар шастир байх бөгөөд тэдгээрт нэгэн утгатай хэрэглэгдэх ойлголтууд байхаас гадна бас янз бүрийн утгаар тайлбарлагдах ойлголтууд ч байдаг. Энэхүү өгүүлэлд “Илт онолын чимэг” дэх “Хамгийг айлдагч” хэмээх ойлголтын түгээмэл утгыг гаргахыг зорилоо.

Эх сурвалжийн утга агуулгын талаархи анхан эртний тайлбарыг хадгалах замаар өнөө үед сэргээн тайлбарлах үйл ажиллагаа нь өөрөө герменевтик судалгаа болдог. Эх сурвалжийг судлах герменевтик аргазүй нь тухайн сурвалжийн талаар өгүүлж буй номлооч, судлаачын үзэл баримтлалыг үл харгалзан эх сурвалж дахь ойлголт ухагдахууныг субьектээс нь салган судлах аргазүй юм. Герменевтик аргазүйгээр зөвхөн гүйцэд боловсорсон сурвалжийг л судална. Өөрөөр хэлбэл, тухайн сурвалж дахь ойлголтууд нь нэгэнт хэвшсэн утгыг илэрхийлсэн байдаг. Иймээс герменевтик аргазүй нь эх сурвалж дахь ойлголтуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн утгыг гаргахад чиглэнэ.

Билиг барамидын зава шастир “Илт онолын чимэгийн” олон тайлбар байдаг бөгөөд үг хэллэг, бүтэц агуулгын хувьд зөрөх, зарим ойлголт, асуудлуудыг янз бүрээр тайлбарлах өнгө аяс байдаг ч нийтээр хүлээн зөвшөөрөх тайлбарыг судлан гаргаж болно. Ингээд “Илт онолын чимэгт” авч үздэг найман бодоос “Хамгийг айлдагчийг” герменевтик аргазүйгээр тайлбарлахыг оролдье.

Хамгийг айлдагч

Өнгөрсөн, одоо, ирээдүй хязгааргүй цагийн хязгааргүй орон зай дахь хамаг төрөлхтнийг нэгийг ч үлдээлгүй бүхнийг хамран мэдсэн бурханы мэдлэгийг “Хамгийг айлдагч” гэнэ. Хамгийг айлдагч нь хамаг төрөлхтнийг Номын хүрдэнд хөтлөн оруулах зорилготой. Мөн хамаг төрөлхтөн Номын мөрөөр замнахын эцсийн зорилго нь Бурханы буюу Хамгийг айлдагчийн билиг чадварт хүрэх явдал болно. Энэхүү Хамгийг айлдагчийн билиг чадварыг арван утгаар илэрхийлдэг:

1. Сэтгэл үүсгэх

Сэтгэл үүсгэх гэдэг нь Хамгийг айлдагч буюу Бурханд байх ёстой хамгийн гол чанар - хамаг амьтны тусыг бодох сэтгэл болой. Бурхан хэзээ ч өөрийгөө боддоггүй, харин хамаг төрөлхтөний (там, бирд, адгуус, хүн, тэнгэр нарын) амар амгаланг хүсэх асар дээд ёс суртахууныг үзүүлнэ. Зөвхөн ийм ёс суртахуун л Бурхан болохын гол үндэс болдог. “Хамаг төрөлхтөний тусыг бодсон сэтгэлийг үүсгэх нь өөрийн нөхөр¹⁶⁴ болох бусдын тусад төгс ухаарсан бодийг¹⁶⁵ зорих дуршилтай¹⁶⁶ адил төгс ухаанд¹⁶⁷ төрсөн их хөлгөний

¹⁶⁴ Хамгийн ойр байх, ямагт хамт байх сэтгэлийн чанарыг нөхөр гэжээ.

¹⁶⁵ Ямагт бусдын тусыг бодох нь өөрийнх нь жинхэнэ мөн чанар болсон бодгаль

¹⁶⁶ Аливаа хүсэл нь зовлон төрүүлдэг учир зовлонгоос гэтэлсэн, бусдын тусыг бодохыг гол зорилгоо болгосон хүсэл эрмэлзлийг дуршил хэмээжээ.

¹⁶⁷ Адил төгөлдөр билиг ухаан гэдэг нь тухайн бодгалийн төрөлхийн зан чанар гэсэн утга болно.

мөрийн орох үүд нь болж чадах язгуурыг ялгах их хөлгөний гол сэтгэлийн ялгаатай оюун” юм. Түүнийг ерөөхийн сэтгэл үүсгэх¹⁶⁸, орохын сэтгэл үүсгэх¹⁶⁹ гэж хоёр ялгана. Жишээ татан үзүүлэхийн үүднээс газар мэт сэтгэл үүсгэх, алт мэт сэтгэл үүсгэх, саран гарах мэт сэтгэл үүсгэх, гал мэт сэтгэл үүсгэх, орд мэт сэтгэл үүсгэх, эрдэнэ гарахын орон мэт сэтгэл үүсгэх, далай мэт сэтгэл үүсгэх, очир мэт сэтгэл үүсгэх, сүмбэр уул мэт сэтгэл үүсгэх, эмч мэт сэтгэл үүсгэх, буяны садан мэт сэтгэл үүсгэх, чандмань эрдэнэ мэт сэтгэл үүсгэх, нар мэт сэтгэл үүсгэх, номын яруу эгшиг дуурсах мэт сэтгэл үүсгэх, хаан мэт сэтгэл үүсгэх, сан хөмрөг мэт сэтгэл үүсгэх, их зам мэт сэтгэл үүсгэх, уналга мэт сэтгэл үүсгэх, усан сан мэт сэтгэл үүсгэх, яруу дуун мэт сэтгэл үүсгэх, их мөрний урсгал мэт сэтгэл үүсгэх, үүл мэт сэтгэл үүсгэх хэмээн 22 зүйл болгон ангилдаг байна. Газрын хуваарь¹⁷⁰ нь их хөлгөний чуулганы мөрөөс бурханы газарт хүртэл байна”.

2. Увьдис

Бурханы хутгийг олохоор зорьж бясалгалд суралцахын өмнө бурханы сургаалыг сонсч сүсэг бишрэл үүсгэх нь түүнд суралцах хүсэл эрмэлзлийг дэгжээх сэтгэлзүйн хүчин зүйл болдог учраас бурханы сургаалын гайхамшигт чанарыг илэрхийлж “увьдис” гэдэг. Увьдис - их хөлгөний сэтгэл үүсгэх хялбар аргыг үзүүлсэн их хөлгөний ойлголт. Түүнийг 1) бүтээгч өөрийн мөн чанарт номлосон ёс, 2) дөрвөн үнэнийг зоригдлын орон болгон номлох увьдис, 3) чухаг дээд гурвыг шүтээнд номлох увьдис, 4) залхууралгүй хичээнгүйгээр номлох увьдис, 5) бүхнийг алжаалгүй хичээхэд номлох увьдис, 6) мөрийг бүхэнд барихад хичээх увьдис, 7) махан мэлмий, тэнгэрийн мэлмий, билгүүний мэлмий, номын мэлмий, бурханы мэлмий тавыг номлох увьдис, 8) рид хувилгааны илт мэдэл, тэнгэрийн чихний илт мэдэл, бусдын сэтгэлийг мэдэх илт мэдэл, урьдын орныг даган санах илт мэдэл, тэнгэрийн нүдний илт мэдэл, хураах барагдахыг номлох илт мэдэл зургааг номлох увьдис, 9) үзэх мөрийг номлох увьдис, 10) бясалгахын мөрийн номлох увьдис хэмээн арав ангилна. Газрын хуваарь мөрд ороогүйгээс бурханы газар хүртэл байна.

3. Магад ялгахын хувь зохилдох

Бурханы сургаалыг сонсон биширч, түүнийг сэтгэлдээ шингээхээр бясалгасаар эгэл төрөлхтөний сэтгэлийн чанараас өөр дээд сэтгэлийн чанар эзэмшиж эхлэх үеийг барилдлага мөр гэх ба барилдлага мөр нь дотроо илч, үзүүр, хичээнгүй, дээд ном гэсэн дөрвөн дэд мөртэй. Эдгээр дөрвөн мөр тус бүрийн бясалгалаар олсон сэтгэлийн шинэ дээд чанаруудыг “Магад ялгахын хувь зохилдох” хэмээжээ. Магад ялгах хувийг зохилдуулан төгс даган гарсан илт мэдлийн язгуурт оршсон ба үнэний илт мэдлийг даган зохилдуулсан их хөлгөний ертөнцийн мөр нь их хөлгөний мөрийн мөн чанар мөн. Үүнийг их хөлгөний барилдахуйн мөрийн илч, үзүүр, тэвчээр, номын дээд гэж дөрөв ангилна. Газрын хуваарь нь их хөлгөний барилдлагын мөрд л гагцхүү байна.

4. Бүтээлийн шүтээн

Их хөлгөний мөрөөр суралцсаар бий болох сэтгэл ухааны шинэ чанаруудыг бүхэлд нь “Бүтээл” гэнэ. Бүтээлийн хувиршгүй суурь үндсийг “Бүтээлийн шүтээн” гэнэ. Бүтээлийн шүтээнийг Бурханы чанар ч гэж ойлгож болно. Бурханы чанар буюу “Бүтээлийн шүтээн” нь бүх төрөлхтөнд байдаг чанар юм. Үүгээр хэн ч бурханы хутгийг олж чадна гэдгийг

¹⁶⁸ Бусад төрөлхтөнийг өөрийнхөө ээж хэмээн сэтгэх, ачийг нь санах, ачлах, асрах, нигүүлсэх, үлэмж гэсэн зургаан сэтгэл дараалан үүсгэж бодь сэтгэлийн ерөөл буюу урьдач бэлтгэл сэтгэл үүснэ.

¹⁶⁹ Бодь сэтгэлийг Бурханы сэтэл рүү орсон гэсэн утгаар орох сэтгэл хэмээдэг.

¹⁷⁰ Буддын сургаалд эгэл төрөлхтөн нь Буддын заасан аргаар бясалгасаар бурханы хутгийг олох чадалтай гэж үзэх ба үүнд хүрэх үйл ажиллагаа нь чуулган, барилдлага, үзэх, бясалгах, үл суралцах гэсэн таван үе шат буюу мөрийг туулж бурханд хүрнэ. Эдгээр үе шат, зам мөр бүрийн чухам аль үед ямар чадвар илрэхийг тодорхойлсон ангиллыг “Газрын хуваарь” гэдэг.

үзүүлдэг. Барилдлагын мөрөөр суралцах явцад: 1) сэтгэл ямар нэг юманд зовнин тарчлах, 2) төөрөлдсөн нөхөд сэлтэстэй ойр байх, 3) ядуу зүдүүгийн эрхээр номд суралцаж чадахгүй байх, 4) бусдын эрхшээлд байх гэсэн саад тотгорууд илэрч гардаг байна. Их хөлгөний бүтээх шүтээний мөн чанарын язгуур нь бодь сэтгэлтний угт буй хоосон чанар мөн. Их хөлгөний бүтээх бодьтой шүтээний суурь болдог зүйл нь их хөлгөний бүтээлийн мөн чанарын язгуурын бэлгэ чанар юм. Түүнд арван гурван шүтээний ном бүтээлийн арван гурван хоосон чанар байна. Арван гурван бүтээл нь их хөлгөний магад үйлдүүлэгч хувийг нийцүүлэх дөрөв, их хөлгөний үзэх мөр, бясалгахуй мөр хоёрыг нэмээд мэдлийн зургаан ном, ерөндөгийн бүтээл, тэвчихийн бүтээл, тэдгээрийн төгсгөлд хүрэхийн бүтээл, билгүүний зүрхний нигүүлсэнгүйн бүтээл, нийтийн бус шавийн бүтээл, бусдын тусыг дараалан үйлдэх бүтээл, билгүүнийг хичээх үгүй ч орохын бүтээл гэж ангилна. Газрын хуваарь нь их хөлгөний чуулганы мөрөөс үргэлжлэлийн эцэс хүртэл байна.

5. Бүтээлийн зорилго

Бүтээлийг эзэмшихийн тулд бясалгалд суралцахдаа зайлшгүй мөрдөх ёстой зүйл бий. Тэдгээрийг бүтээлийн зорилго гэнэ. Илт онолын чимэгт бүтээлийн зорилгыг арван нэгэн зүйлээр тодорхойлсон байдаг ч энэ нь бурханы сургаалын бүх номоор дэлгэрэх утгатай. Их хөлгөний бүтээх зоригдол- их хөлгөний бүтээхийн тухайд сэжгийг таслан үйлдэх суурь нь их хөлгөний бүтээлийн зорилгын мөн чанар юм. Түүнтэй мэдэгдэхүүн утга нэг болой. Үүнийг буян, нүгэл, эш үзүүлээгүй, ертөнцийн таван цогцос, ертөнцөөс нөгчсөн дөрвөн самади, цувирлын таван цогцос, цувиралт үгүй ойр санасан дөрөв, хураан үйлдсэн гурван ертөнц, түүнчлэн эс хураан үйлдэгч, нийтийн дөрвөн самади, нийтийн бус чадагчийн арван хүч нийлээд арван нэгэн зүйл болгон ангилна. Газрын хуваарь нь суурьт үзсэн бүхний дээр байна.

6. Бүтээлийн тусгайлал

Бүтээлийг бясалгах явцад чухам юун дээр гол анхаарлаа хандуулах ёстой вэ гэдгийг Бүтээлийн тусгайллаар тодорхойлдог. Тухайлбал, бодьсатва нь гурван зүйлийг удирдлага болгон хичээнгүйлэн суралцана. Юуны тулд үйлдэн орсноор эцэст нь хүрсэн үр нь их хөлгөний бүтээлийн тусгайлын мөн чанар юм. Түүнтэй бурхан утга нэг. Түүний дотор нь их сэтгэлтэн, их тэвчээртэн, их мэдэлтэн гэж гурав ангилна. Газрын хуваарь нь ганц бурханы газарт байна. Хамгийг айлдагчийн сүүлчийн дөрвөн утга нь бүтээлд хүрэх дөрвөн аргыг илэрхийлнэ. Үүнд:

7. Хуягийн бүтээл

Зургаан барамид тус бүрийн бясалгал дотор зургаан барамид зургуул багтдаг гэсэн утгыг хуягийн бүтээлээр гаргадаг. Өглөг тэргүүтэн билиг барамидын тус тусад нь дотор нь зургаа зургаагаар бүрдүүлэн хурааснаар анхааран авахыг хүсэх санааны үйлдэл агуу ихийг барьсан сэтгэлийн егүзэр нь хуяг бүтээхийн мөн чанар юм. Түүнтэй бодь сэтгэлтний айлдвар утга нэг. Үүнийг дотор нь өглөгийн хуягийн бүтээл зургаа, шагшаабадын хуягийн бүтээл зургаа, хүлцэхүйн хуягийн бүтээл зургаа, хичээнгүйн хуягийн бүтээл зургаа, дияаны хуягийн бүтээл зургаа, билиг билгүүний хуягийн бүтээл зургаа лугаа гучин зургаа болой. Газрын хуваарь нь их хөлгөний чуулганы мөрөөс үргэлжлэлийн эцэс¹⁷¹ хүртэл болой.

8. Орохуй бүтээл

Бодьсатвын бясалгал нь бие сэтгэлийн тэвчээр хатуужил шаардсан урт хугацааны суралцах үйл ажиллагаа мөн боловч зөв бясалгал нь эцсийн эцэст сэтгэлийн тааламжит уур амьгалыг буй болгодог. Ийнхүү бясалгалын тааламжит байдал буюу баясгаланд хүрэх нь орохуй бүтээл болно. Их хөлгөний шалтгаан үрийн номыг алинаар нь ч

¹⁷¹ Үл суралцах мөрийг үргэлжлэлийн эцэс ч гэж нэрлэнэ.

найруулан хичээнгүйг голлохын үүднээс анхааран авах сэтгэлийн егүзэр нь орохуйн бүтээлийн мөн чанар юм. Үүнийг дотор нь дияаны дүрс үгүйд орохын бүтээл, өглөг тэргүүтэн зургаан барамидад орохын бүтээл, үзэхүйн мөр, бясалгахуйн мөр, үл суралцахын мөр, ялгамжаат мөрд орохын бүтээл, асрахуй тэргүүтэн ханьцашгүй дөрөвт орохын бүтээл, зоригдол үгүй төгөлдөрт орохын бүтээл, гурван ертөнцөд тийн ариунаар бүтээл, тусгайлан үйлдэгчид орохын бүтээл, зургаан илт мэдэлд орохын бүтээл, тийн бүгдийг айлдагчид орохын бүтээл хэмээн 9 ангилах болой. Эдгээр нь сэтгэлийн баясгалант төлөв байдалд оруулах хүчин зүйлүүд юм. Газрын хуваарь нь их хөлгөний барилдлагын мөрийн илчээс үргэлжлэлийн эцэс хүртэл орших болно.

9. Чуулганы бүтээл

Ёс суртахуун ба танин мэдэхүйн дээд чанарыг хуримтлуулах нь чуулганы бүтээл болой. Энэхүү хоёр чуулганыг агуу ихээр барихын үүднээс их хөлгөний барилдлагын мөрийн дээд номын дотор доороос ялгамжаатайгаар гарсан өөрийн үр их бодь сэтгэлтэнд гарсан сэтгэлийн егүзэр нь чуулганы бүтээлийн мөн чанар мөн. Үүнийг их нигүүлсэнгүйн чуулганы бүтээл, өглөг тэргүүтэн зургаан барамидын чуулганы бүтээл, амирлангуй оршихын чуулганы бүтээл, үлэмж үзэхийн чуулганы бүтээл, хослон барилдах мөрийн чуулганы бүтээл, арганд мэрэгжсэний чуулганы бүтээл, билгүүний чуулганы бүтээл, буяны чуулганы бүтээл, мөрийн чуулганы бүтээл, тогтоолын чуулганы бүтээл, газрын чуулганы бүтээл, ерөндөгийн чуулганы бүтээл гэж 17 ангилна. Газрын хуваарь нь их хөлгөний барилдлагын мөрийн номын дээдийн ихээс үргэлжлэлийн эцэс хүртэл байна.

10. Магад гарах бүтээл

Бүтээлийг гарцаагүй эзэмшиж хамгийг айлдагчийн эцсийн үр дүнд хүрснийг магад гэрэх бүтээл гэнэ. Хамгийг айлдагчид эргэлзээгүй магадтай хүрсэн ариун газрын егүзэр нь магад гарахын бүтээлийн мөн чанар юм. Үүнд тухайлан үйлдэгчийн магад гарах бүтээл, тэгш ямагтын магад гарахын бүтээл, сэтгэлтний утгыг бүтээх магад гарах бүтээл, шамдал үгүй аяндаа гарах магад гарах бүтээл, шинжлэн таслахын эцсээс нөгчсөн магад гарах бүтээл, гурван хөлгөний утгыг олсон магад гарах бүтээл, тийн бүхнийг айлдагчийн магад гарахын бүтээл, мөрийн орныг мэдэгч ухааны магад гарах бүтээл гэж 8 ангилах болой. Газрын хуваарь нь гурван ариун газарт байх болно.

Илт онолын чимэгт Хамгийг айлдагч зөвхөн бурханд буй гэсэн байх ба билиг барамидын сургаалаар бурхан хэмээх нь ертөнцийг бүтээгч эзэн тэнгэр бус, ахуйн бүхэл нэгдмэл түгээмэл болохыг илэрхийлсэн утга болой. Ингээд хүн ахуйг танин барихдаа зөвхөн харьцангуйд ухаардаг бус түгээмэл дээд утгын мэдлэгийг илэрхийлж чадна хэмээн үздэг байна. Нэгэн ахуй нь түгээмэл утгаараа олон бус цорын ганц, нэг л нэгдмэл ахуй байх тул түүнийг яг байгаагаар нь алдаа мадаггүйгээр, юмс үзэгдлийг олон холбоо харилцаанаас нь салгалгүй бүхэлд нь тусгах тусгал нь ахуйгаас ангид, өөр байх учиргүй, ахуй өөрөө байх бөгөөд энэ тохиолдолд субъект ба объектийн ялгал гарахгүй болно. Билгийг хүний дасгал сургуулиар хүрсэн чадвар гэхээсээ тодорхой нөхцөлд хүн төрөлхтөнд илрэх түгээмэл ахуй буюу түүнчлэн чанар (tathata) гэдэг. Энэ учраас дээд утгын үнэнийг тусгасан мэдлэг нь ахуй өөрөө мөн болно.

Илт онолын чимэг дэх Хамгийг айлдагч хэмээх ойлголт нь ерөөс сансараас гэтэлсэн дээд утгын үнэнийг олох сэтгэл-танин мэдэхүйн үйл ажиллагааг номлодог байна. Хамгийг айлдагчийн гол утга болох сэтгэл үүсэхүйн талаар 3.Агваанбалдан тайлбартаа: “Их хөлгөний сэтгэлийг үүсгэгч нь, тухайд үйлдэх эдүгээ дээрээс бусдын тусад амьтан хамаг бүгдийн тусын тул олж үйлдэх үнэхээрийн туулсан бодийг хүсэх сэтгэлийн тийн мэдэл ялгавартан мөн болой” хэмээснээс үзэхүл бодь сэтгэл нь тусгаар хүн, бүлэг хүн, тодорхой анги болон тодорхой орчин, тодорхой цаг хугацаанд захирагдсан ёс суртахууны тодорхой үзэл баримтлалаас ангижирч ерөөс бүхий л төрөлхтөн, бүхий л үе хугацаанд хамаарагдах түгээмэл ёс суртахууныг илэрхийлдгээрээ феноменаль төлвөөс ялгардаг байна.

Буддын билиг барамидын сургаал нь хүн ертөнцийг буруу ташаа мэдсэнээс болж алдаанд хүрдэг, тийнхүү алдаж эндэх шалтгаан нь хүний сэтгэлд нуугдан байдаг гэж үзээд

хүний сэтгэлийн бүхий л төлөв байдлуудыг судлан гаргаж, улмаар мэдлэгийг төөрөгдүүлдэг аливаа хүчийг дарж устгасаар, зөвхөн үнэн мэдлэг өгөх төлвүүдийг үлдээдэг бөгөөд ийм байдлыг “хамгийг айлдагчаар” илэрхийлжээ. Хүн юмс үзэгдлийг эгнэгт нотод баримтлахын хамт тэдгээрийг өнгөрсөн одоо ирээдүй цагт нь орон зайн хязгааргүй холбоо харилцаанд нэг мөр баримтлах чадвартай ажээ. Ингэж билиг барамидын сургаал нь хүн сэтгэл оюунаараа ертөнцийн түгээмэл, нэгдмэл байдал, туйлыг хэрхэн оноон барихыг номлосон сургаал болой. Ертөнцийн түгээмлийг тусгасан илт онол нь шууд, ухаалаг, туйлын мэдлэг болно²⁵. Хамгийг айлдагчийн шинжээр хүний оюун ухаан дээд зэргээр хөгжиж боловсорсон үед аливаа юмс үзэгдлийг харьцангуйд авч үзэн орчлон ертөнцийн бүхий л байдлыг үнэмлэхүй ба янагуухи талуудын нэгдэлд нь нэгэн агшинд, нэгэн зэрэг танин барьж чаддаг чадварыг илэрхийлнэ.

Хавсралт

ХАМГИЙГ АЙЛДАГЧИД ХАМААРАХ ДЭД ОЙЛГОЛТУУД

1. Их хөлгөний сэтгэл үүсгэх

- 1) Дэлхий
- 2) Алт
- 3) Сар
- 4) Гал
- 5) Сан
- 6) Эрдэнэ гарахын орон
- 7) Нуур
- 8) Очир
- 9) Уул
- 10) Эм
- 11) Буяны садан
- 12) Чандмань
- 13) Наран
- 14) Дуулал
- 15) Хаан
- 16) Сан
- 17) Их гүүр
- 18) Хөлөг
- 19) Оргилох усан
- 20) Яруу дуун
- 21) Мөрөн
- 22) Үүл

- 1) Хүсэхүй сэтгэл
- 2) Орохуй сэтгэл

- 1) Бишрэн явах
- 2) Үлэмж ариун сэтгэл
- 3) Тойн боловсрол
- 4) Түйтгэрийг тэвчсэн сэтгэл үүсгэх

- 1) Малч мэт
- 2) Сэлбүүрч мэт
- 3) Хаан мэт сэтгэл үүсгэх

²⁵ Гантуяа М. Буддын билиг барамидын философи үзэл. Диссертаци. УБ. 1995, 116 дахь тал

- 1) Янагуухь
- 2) Үлэмж сэтгэл үүсгэх

- 1) Бүдүүн дохионоос болсон
- 2) Номын чанараар олсон сэтгэл

2. Их хөлгөний бүтээлийн увьдас

- 1) Бодот бүтээл дор увьдасласан:
- 2) Дөрвөн үнэн,
- 3) Гурван эрдэнэ,
- 4) Эс шунасан
- 5) Огоот алжаал үгүй
- 6) Мөрийг огоот баригч
- 7) Таван нүдэн
- 8) Зургаан зөн билиг
- 9) Үзэхүй мөр
- 10) Бясалгахуй мөр нүгүүд дор увьдасласан

3. Магад ялгахуй гишүүн

- 1) Барилдлагын мөрийн:
- 2) Илч
- 3) Үзүүр
- 4) Хүлцэнгүй
- 5) Дээд ном

- 1) Зорилго
- 2) Дүр
- 3) Шалтгаан
- 4) Огоот баригч
- 5) Тэвчигдэх атхаг

Их, дунд, өчүүхэн гурван чанарын үүднээс
ялангуяа хэтэрхий лүгээ ялгалын зургаан ном буй.

Дөрвөн атхаг нь:

Бүхнээс нясваанисын баримтын атхаг
Маш ариун баримт атхаг лугаа хоёр
Эдээр буй, Нэрийтгэл дор буй хэмээн баригчийн
баримтлах атхаг хоёр лугаа дөрвөн болой.

4. Бүтээлийн шүтээн, 13 бүтээлийн язгуур:

- 1) Онолын зургаан ном
- 2) Ерөндөг лүгээ тэвчилийн бүтээл
- 3) Тэвчигдэхүүнийг огоот барьсан
- 4) Билиг
- 5) Нигүүлсэхүй
- 6) Ер бус
- 7) Бусдын тусыг зэргээр үйлдэх
- 8) Хичээл үгүй бэлгэ билиг орохуйн бүтээл

- 1) Мөн чанарын язгуур
- 2) Дэлгэрэхийн язгуур

- 1) Ширваан

- 2) Брадигабодь
- 3) Бодьсадвын язгуур
- 4) Магад язгуур
- 5) Магад үгүй язгуур
- 6) Язгуур тасарсан

5. Их хөлгөний бүтээлийн зорилго

- 1) Буян
- 2) Буян бус
- 3) Эш эс үзүүлсэн
- 4) Ертөнцөөс нөгчсөн
- 5) Ертөнцөөс эс нөгчсөн
- 6) Цуврилт ном
- 7) Цуврил үгүй ном
- 8) Хуран үүдсэн
- 9) Хуран эс үүдсэн
- 10) Ерийн ном
- 11) Ер бусын ном

6. Их хөлгөний бүтээлийн тусгайлал

- 1) Их сэтгэл
- 2) Их тэвчил
- 3) Их онол

7. Хуягийн бүтээл

- 1) Өглөг
- 2) Шагшаабдь
- 3) Хичээнгүй
- 4) Хүлцэнгүй
- 5) Дияан
- 6) Билиг

8. Орохуй бүтээл

- 1) Дияан дор орох
- 2) Дүрс үгүйн тэгш оролдохуй дор орох
- 3) Өглөг тэргүүтэн
- 4) Хутагтаны мөр
- 5) Цаглаш үгүй
- 6) Үл зохилдох лугаа төгөлдөр
- 7) Гурван зүйл огоот арилсан
- 8) Тусгайлан үйлдэх
- 9) Зөн билиг
- 10) Хамаг зүйлийг айлдагчид орох

9. Чуулганы бүтээл

1. Нигүүлсэхүйн чуулганы бүтээл
2. Өглөг
3. Шагшааабдь
4. Хичээнгүй
5. Хүлцэнгүй
6. Дияан
7. Билиг
8. Амарлин ахуй
9. Үлэмж үзэхүй

10. Амарлин үлэмж хослон барилдсан
11. Мэргэн арга
12. Бэлгэ билиг
13. Буян
14. Мөр
15. Тогтоол: хүлцэнгүй, ном, утга, тарни: (нарийн тарни, нууц тарни, тогтоол тарни))
16. Арван газар
17. Ерөндөг чуулганы бүтээл

10. Магад гарахын бүтээл

- 1) Тусгайлал
 - 2) Тэгш чанар
 - 3) Амьтны тус үйлдэх
 - 4) Хичээл үгүй
 - 5) Хичээлээс нөгчсөн
 - 6) Тус олсон бэлгэ чанар
 - 7) Хамаг зүйлийг айлдагч
 - 8) Түүний үлэмж мөрийн магад гарах
-
- 1) Айлдалын вишайн бүтээл
 - 2) Барилдлага өвөрчлөнгийн бүтээл

SUMMARY

One of the purposes of the hermeneutic study on philosophical and religious literature is to realize the generally used meaning of categories. So in this article I would like to try realizing general meaning of category "Sarvakarajnana" in the Abhisamayalamkara although there are some different explanations in many commentaries on this shastra.

Sarvajna-jnana is the the first main category of the Prajna-paramita basic shastra "*Ornament of clear realization*". It is the superior knower of all aspects of all objects without exception. It includes ten meanings:

1. The Buddha mind for the sake of all sentient beings.
2. Superior qualities for the Enlightenment.
3. The four branches of the second - Bhavana-marga to the Truth.
4. Foundations of Mahayana achievements.
5. Goal of the Mahayana achievements.
6. Specialties of the Mahayana achievements.
7. Achievement like armor
8. Achievement like entering
9. Achievement like collection
10. Achievement like complication